

“Соёлч хот” дэд хөтөлбөр /ТӨСӨЛ/

Нийтлэг үндэслэл

Хотын соёл гэдэг бол бие биенээ хүндэтгэх, бие биедээ анхаарал халамж тавих, аминчхан бус үзэл бөгөөд иргэдийн хамтран амьдрах, аж төрөх ёс, уламжлал шинэчлэлийг хэрэгжүүлэх явдал юм.

Соёл гэдэг бол зөвхөн соёлын салбар, соёлын байгууллагынханд хамаарах ойлголт хараахан биш учир нийгмийн бүхий л салбарт бусдыг хүндлэх тухай асуудлыг зайлшгүй авч үзэх шаардлагатай. Соёлын үйлчилгээний төрөл зүйлийг олшруулан, хүртээмжийг өргөтгөх, ардын уламжлалт, орчин үеийн соёл, урлагийг хүн төрөлхтний оюуны соёлын ололттой хослуулан хөгжүүлэх, залуу үеийнхэнд өвлүүлэх, иргэний соёлыг төлөвшүүлэхэд чиглэх ёстой.

Олон соёлын урсгал хүч түрэн орж байгаа энэ цаг үед харийн соёлын нөлөөнд авталгүй үндэсний бахархал болсон уламжлалт өв соёл, үнэт зүйлсээ нандигнан дээдэлж, хадгалан хамгаалж шинэ соёлоор баяжуулан хөгжүүлэх асуудал иргэн бүрийн үүрэг болоод байна.

Эцэг өвгөдөөс уламжилж ирсэн хүнлэг ариун ёс заншил, жудаг гээгдэж ахмад настнаа үл хүндлэн үлгэргүй байдал гаргаж архидаан согтуурч, мансуурах донтох явдал хэт их залуужиж байгаа нь бид бүгдийн сэтгэлийг эмзэглүүлж байдаг. Энэ бүхэн нь цаанаа иргэдийн ахуйн соёл, түүнээс ул-баалан гарах хэрэглээний соёлын талаарх доголдлыг илтгэж байгаа хэрэг бөгөөд хамтран аж төрөх, амьдрах соёлыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг бүх нийтийн хэрэг болгох зайлшгүй шаардлага гарч байгаа юм.

Нэг: Хөтөлбөрийн зорилго, зорилт.

Үндэсний бахархал болсон уламжлалт өв соёл, үнэт зүйлсээ нандигнан дээдэлж, үндэстнийхээ соёл урлагийн өвөрмөц онцлогийг хамгаалж хөгжүүлэх, иргэд нь эрүүл, тайван орчинд амьдрах, зөв ёс суртахуунтай, харилцан бие биеэ хүндэтгэсэн, хамтран амьдрах, ажиллах өндөр соёлтой иргэн болон төлөвшүүлэх, иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлж байна.

1.1. Иргэд, олон нийт, өсвөр үеийнхэнд уран сайхны боловсрол, гоо зүйн хүмүүжил олгоход соёл урлаг, боловсролын байгууллагын хамтын ажиллагааг чиглүүлж, тэдэнд зориулсан соёлын арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.2. Хүрээлэн буй орчин, эрүүл мэндэд сөргөөр байгаа орчны бохирдлыг бууруулсан, аюулгүй амгалан тайван амьдрах таатай нөхцөл бүрдсэн, салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурлан иргэдэд ээлтэй төлөвлөлт, соёлтой зан үйлийг төлөвшүүлсэн орчин бүрдүүлнэ.

1.3. Түүх соёл, иргэний үүргээ дээдэлсэн, үүрэг хариуцлагаа биелүүлсэн, гэр бүлийн соёл хүмүүжлийг дээдэлсэн өрхийг бий болгон нэмэгдүүлнэ.

1.4. Соёлын байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, орчин цагийн шаардлагад нийцсэн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ.

1.5 Үйлчлүүлэгчээ дээдэлсэн, үйлчилгээний соёлыг хэвшүүлсэн, тохитой орчныг бүрдүүлсэн, байгууллага, аж ахуйн нэгж, үйлчилгээг нэмэгдүүлнэ.

Хоёр: Хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн

2.1 Иргэд, олон нийт, өсвөр үеийнхэнд уран сайхны боловсрол, гоо зүйн хүмүүжил олгоход соёл урлаг, боловсролын байгууллагын хамтын ажиллагааг чиглүүлж, тэдэнд зориулсан соёлын арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

а) Соёлын биет бус өв тээгчдийг илрүүлэн хөгжүүлэх, сурталчлан таниулах, үнэт өвийг шавилан сургаж өвлүүлнэ

б) Иргэд олон нийт, өсвөр үеийг соён гэгээрүүлэх урлагийн арга хэмжээ, үзвэр үйлчилгээг нэмэгдүүлнэ.

в) Соёлын байгууллагаас соёлч хот сэдвээр цуврал зохиомжит видео бүтээл хийж, орон нутгийн мэдээллийн хэрэгслээр нийтийн хүртээл болгож соён гэгээрүүлнэ.

г) Бага сургуулийн сургалтыг дэмжих үйл ажиллагааны цагийг хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, авъяас чадварыг нь илрүүлэх, амьдрах арга ухаан, соёл уламжлалаа өвлүүлэх, гоо зүйн хүмүүжил олгоход чиглүүлнэ.

д) Сургуулиудад явагдаж буй хичээлээс гадуур соёл урлаг, биеийн тамирын дугуйланг нэмэгдүүлж, авъяас чадварыг хөгжүүлнэ.

Хүрэх үр дүн: Хүүхэд багачуудын гоо зүй, үндэсний ёс заншил, ёс суртахуун ухамсар сайжирч хариуцлагатай иргэн бий болно.

2.2 Хүрээлэн буй орчин, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг орчны бохирдлыг бууруулсан, иргэдийн аюулгүй, амгалан тайван амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлсэн, салбар хоорондын хамтын ажиллагааг дэмжсэн иргэдэд ээлтэй төлөвлөлт, соёлтой зан үйлийг төлөвшүүлсэн орчин бүрдүүлнэ.

а) Эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж байгаа хамт олон, нэгж байгууллагыг урамшуулж, сурталчилна

б) Гэмт хэрэг хэв журмын зөрчилгүй, архи, тамхины хэрэглээнээс татгалзах хөдөлгөөнийг өрнүүлнэ.

в) Байгаль орчин сөрөг нөлөөгүй цэвэр технологи хэрэглэгчийг урамшуулан дэмжинэ

г) Гудамж талбайд ил задгай хог хаягдал хаяхгүй байх, хог хаягдал ангилах зориулалтын савыг нэмэгдүүлнэ

д) Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн албан ёсны нэр, хаяг хэрэглэж хаягжуулна

Хүрэх үр дүн: Иргэд, олон нийт, салбар хоорондын оролцоо сайжирч эрүүл, аюулгүй орчин бүхий хот бий болно.

2.3 Түүх соёл, иргэний үүргээ дээдэлсэн, үүрэг хариуцлагаа биелүүлсэн, гэр бүлийн соёл хүмүүжлийг дээдэлсэн өрхийг бий болгон нэмэгдүүлнэ.

а) Угийн бичиг хөтлөх талаар сургалт, сурталчилгаа явуулж, угийн бичиг хөтлөх өрхийг нэмэгдүүлнэ

б) Иргэний бичиг баримтын үзлэг шалгалтыг зохион байгуулан зөрчил арилгаж, иргэний үүргээ сайн биелүүлдэг өрх, иргэнийг шалгаруулна

г) Хотын соёл, иргэний соёлын талаар сургалт сурталчилгаа зохион байгуулна

Хүрэх үр дүн: Хариуцлагатай, өв соёлоо дээдэлсэн иргэн бүхий нийгмийн орчин бүрдэнэ.

2.4 Соёлын байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх, орчин цагийн шаардлагад нийцсэн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ.

а) Алслагдсан хорооны иргэдэд соёлын үйлчилгээ хүргэх техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулна

б) Соёлын ордны багш ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамруулна

в) Соёлын ордны хөгжмийн зэмсэг, хувцас, хэрэглэлийг нэмэгдүүлнэ

д) Асвөр үеийнхнийг хөдөлмөрч, хүнлэг, ахмад үеэ хүндлэн дээдэлдэг, ёс заншлаа эрхэмлэдэг үзэл санаагаар хүмүүжүүлэхэд чиглүүлэх, үйлчилгээний төрөл зүйлийг олшруулна

Хүрэх үр дүн: Урлаг соёлын байгууллага, суралцагч, багш, ажилтнуудын сурч, хөгжих, ажиллах таатай орчин бүрдэнэ.

2.5 Үйлчлүүлэгчээ дээдэлсэн, үйлчилгээний соёлыг хэвшүүлсэн, тохитой орчныг бүрдүүлсэн, байгууллага, аж ахуйн нэгж, үйлчилгээг нэмэгдүүлнэ.

- а) Байгууллага, нийтийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүдээс иргэдэд хүргэх үйлчилгээ, зохион байгуулалтын арга хэмжээнд цагийн хуваарийг нарийн баримтлан мөрдүүлнэ
- б) Үйлчилгээний байгууллагын ажилтнууд байгууллагын өнгө төрхийг илэрхийлсэн, үйл ажиллагаандаа тохирсон жигд хувцас, тухайн үйлчилгээний стандарт хангасан байна
- в) Мэндлэх, хүндлэх, угтах, үдэх үйлчилгээ, харилцааны соёлыг төлөвшүүлэх, иргэн үйлчлүүлэгчдэдээ гомдол төрүүлэхгүй байна
- г) Орчин цагийн шаардлага хангасан ухаалаг техник, төхөөрөмж нэвтрүүлж, үйлчилгээндээ ашиглана
- д) Ажилчид, алба хаагчдынхаа ажиллах орчинг сайжруулсан, алжаал тайлах, эрүүл мэндээ хамгаалах ая тухай нөхцөлийг бүрдүүлнэ

Хүрэх үр дүн: Ая тухтай үйлчилгээ, ажиллах таатай орчин нөхцөл бүрдсэнээр хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэнэ.

Гурав: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална.

- 3.1 Хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа, холбоонд тулгуурлах;
- 3.2 Урлаг соёлын алдартан, соёлын өв тээгч, ардын авъяастан, сайн дурын уран сайханч, иргэдийн санал, санаачлагд тулгуурлах;
- 3.3 Нийгмийн түншүүд, иргэний болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаанд түшиглэх;

Дөрөв: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа.

Хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

Тав: Хөтөлбөрийн хяналт шинжилгээ, шалгуур үзүүлэлт.

- 5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг Соёлч хот хөтөлбөрийн ажлын хэсэг.
- 5.2. Нэгж, байгууллага, хороод хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажлаа хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллана, менежерийн ажил дүгнэх үзүүлэлт, аж ахуйн нэгжийн нийгмийн хариуцлагыг илтгэх үзүүлэлт болгоно.

Зургаа: Хөтөлбөрийн санхүүжилт

- 6.1. Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан арга хэмжээний шалгаруулалт, шагнал урамшуулалд зарцуулах хөрөнгийг Засаг даргын нөөц сан
- 6.2. бусад эх үүсвэр.